



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 164

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дархан-Уул аймгийн Татварын хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох 27 нэрийн, нийт 35,462,764.25 (гучин таван сая дөрвөн зуун жаран хоёр мянга долоон зуун жаран дөрвөн төгрөг хорин таван мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 13,606,482.23 (арван гурван сая зургаан зуун зургаан мянга дөрвөн зуун наян хоёр төгрөг хорин гурван мөнгө) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Татварын ерөнхий газрын дарга Б.Заяабал, Дархан-Уул аймгийн Татварын хэлтсийн дарга Х.Оюунцэцэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн
 16% дугаар тогтоолын хавсралт

Дархан-Уул аймгийн татварын хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, үлдэгдэл өртөггүй,
 ашиглах хугацааг сунгаж үнийг шинэчлэн тогтоох хөрөнгийн жагсаалт

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, төрөл	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт балансын үнэ /хуримтлагдсан элэгдэл/ (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)		Цаашид ашиглах хугацаа (жилээр)
						Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)	
1	Тоосгон суурьтай төмөр хашаа	12/31/2018	109	1,976,810.00	1,976,810.00	9,067.94	988,405.00	5
2	Принтер олон үйлдэлтэй	12/24/2015	2	329,900.00	659,800.00	164,950.00	329,900.00	3
3	Канон Куосега 1800	12/23/2015	1	1,699,900.00	1,699,900.00	849,950.00	849,950.00	3
4	Өнгөт принтер Epson L360	7/17/2018	1	520,000.00	520,000.00	260,000.00	260,000.00	3
5	Проектрын дэлгэц	7/17/2018	1	407,000.00	407,000.00	203,500.00	203,500.00	3
6	Зөөврийн компьютер Делл испирон 5000	9/14/2018	1	2,321,000.00	2,321,000.00	1,160,500.00	1,160,500.00	3
7	Принтер МФ3010 канон	9/14/2018	2	517,000.00	1,034,000.00	258,500.00	517,000.00	3
8	HP pro-2000 скайнер	6/19/2019	1	1,300,000.00	1,300,000.00	650,000.00	650,000.00	3
9	Ухаалаг самбар Екаа 65-инч	9/9/2019	1	6,963,000.00	6,963,000.00	1,392,600.00	1,392,600.00	3
10	Нисдэг дүрс буулгагч	12/17/2019	1	9,280,000.00	9,280,000.00	2,784,000.00	2,784,000.00	3
11	Тог баригч	9/9/2019	1	949,900.00	949,900.00	474,950.00	474,950.00	3
12	Тв Samsung /1 Цэг/	12/31/2012	1	999,999.00	999,999.00	399,999.60	399,999.60	3
13	Асар	12/31/2012	1	800,000.00	800,000.00	320,000.00	320,000.00	5
14	Босс сандал	12/22/2011	5	86,000.00	430,000.00	43,000.00	215,000.00	5
15	Компьютерийн ширээ	6/1/2012	3	60,000.00	180,000.00	30,000.00	90,000.00	5

16	Нэг цэгийн ширээ	1/1/2007	8	300,000.00	2,400,000.00	150,000.00	1,200,000.00	5
17	Сандал /босс/	12/31/2012	1	519,900.00	519,900.00	259,950.00	259,950.00	5
18	Сандал /г.төлөгчийн өрөө/	12/22/2011	5	50,000.00	250,000.00	25,000.00	125,000.00	5
19	Сандал шинэ	12/31/2012	5	99,900.00	499,500.00	49,950.00	249,750.00	5
20	Тумбочка	12/31/2012	1	189,900.00	189,900.00	94,950.00	94,950.00	5
21	Шар ширээ	6/1/2012	4	132,766.00	531,064.00	66,383.00	265,532.00	5
22	Шилэн шкаф	6/1/2012	2	83,384.00	166,768.00	41,692.00	83,384.00	5
23	Шилэн шкаф	6/1/2012	1	138,460.25	138,460.25	69,230.13	69,230.13	5
24	Шилэн шкаф	6/1/2012	2	141,716.00	283,432.00	70,858.00	141,716.00	5
25	Ширээ	12/31/2012	1	249,900.00	249,900.00	124,950.00	124,950.00	5
26	Шкаф суурь	6/1/2012	4	140,379.00	561,516.00	70,189.50	280,758.00	5
27	Шкаф суурь	6/1/2012	1	150,915.00	150,915.00	75,457.50	75,457.50	5
					35,462,764.25 (гучин таван сая дөрвөн зуун жаран хоёр мянга долоон зуун жаран дөрвөн төгрөг хорин таван мөнгө)		13,606,482.23 (арван гурван сая зургаан зуун зургаан мянга дөрвөн зуун наян хоёр төгрөг хорин гурван мөнгө)	
НИЙТ ДҮН			166					